

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/37

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
нарийн бичгийн дарга чөлөөлөх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Батсүлд овогтой Оюунболд нь 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын албан үүргээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн түүнийг ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/38

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
нарийн бичгийн дарга  
томилох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн даргын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн санал болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Хүчитбаатар овогтой Хулан (РД: -ыг томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилогдсоныг Компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр), Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан) нарт үүрэг болгосугай.



## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/39

Улаанбаатар хот

### **Арилжааны банкнууд дахь дансны баталгаат гарын үсэг зурах этгээдийг солих тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.5, 9.6.23 дахь заалтууд болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн бүтэц зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 2025/145 тоот тушаалаар Нямаа овогтой Мөнхбат нь Санхүү хариуцсан захирлаар, Компанийн Ерөнхий нягтлан бодогч Ганболд овогтой Золжаргал нь өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдөр чөлөөлөгдөж, Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 2025/164 тоот тушаалаар Чулуунбат овогтой Саруултуяа нь Компанийн Ерөнхий нягтлан бодогчоор тус тус томилогдсон болохыг дурдсугай.
2. Компанийн Монгол улсад бүртгэлтэй Арилжааны банкнуудад эзэмшиж буй төгрөгийн болон ам.долларын бүхий л дансны захиран зарцуулах эрх буюу 1-р (нэгдүгээр) гарын үсэг зурах эрх нь Компанийн Гүйцэтгэх захирал Цэрэндорж овогтой Ууганбаяр (РД: \_\_\_\_\_) -т хэвээр хадгалагдаж байгааг тэмдэглэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт дурдсан өөрчлөлттэй холбоотойгоор Монгол улсад бүртгэлтэй Арилжааны банкнуудад эзэмшиж буй төгрөгийн болон ам.долларын бүхий л дансны захиран зарцуулах эрх буюу 2-р (хоёрдугаар) гарын үсэг зурах эрхийг Компанийн Ерөнхий нягтлан бодогч Чулуунбат овогтой Саруултуяа (РД: \_\_\_\_\_) д олгосугай.
4. Монгол улсад бүртгэлтэй Арилжааны банкнуудад эзэмшиж буй төгрөгийн болон ам.долларын бүхий л дансны захиран зарцуулах эрх буюу Компанийн 1-р (нэгдүгээр) болон 2-р (хоёрдугаар) гарын үсгийг орлон зурах эрхийг Компанийн Санхүү хариуцсан захирал Нямаа овогтой Мөнхбат (РД: \_\_\_\_\_) -д энэхүү тогтоолоор олгосугай.
5. Компанийн Монгол улсад бүртгэлтэй Арилжааны банкнуудад эзэмшиж буй төгрөгийн болон ам.долларын бүхий л дансны захиран зарцуулах бүх эрхийг энэхүү тогтоолын 2 болон 3 дахь хэсэгт дурдсан 1-р болон 2-р гарын үсэг зурах этгээдүүд хамтран хэрэгжүүлэх болохыг тэмдэглэсүгэй.

6. Энэхүү тогтоолын 4 дэх хэсэгт дурдсан Компанийн 1-р (нэгдүгээр) болон 2-р (хоёрдугаар) гарын үсгийг орлон зурах эрхийн хязгаарыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
7. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан арилжааны банкнуудад хандан баталгаат гарын үсэгт орсон өөрчлөлтийг бүртгүүлэх (хүсэлт гаргах, анкет, маягт бөглөх, баримт бичиг гарган өгөх, төлбөр хураамж төлөх, хариу хүлээн авах болон ийнхүү бүртгүүлэхтэй холбоотой бүхий л ажиллагаа хамаарна), ийнхүү бүртгүүлэхтэй холбоотой бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Цалингийн нягтлан бодогч Төмөр овогтой Оюунсүвд (РД: )-д олгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/40

Улаанбаатар хот

**2025 оны санхүүгийн тайланд  
хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн АХ-25/05 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, тэдгээртэй гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.



## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр

№ 25/41

Улаанбаатар хот

### **Гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн АХ-25/06 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь “ОНДО” ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр 2022/92 дугаартай “Интернет үйлчилгээний гэрээ”-г, 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Интернет үйлчилгээний гэрээнд нэмэлт оруулах тухай гэрээ”-г тус тус байгуулж байсан болохыг тэмдэглэсүгэй.
2. Компанид “ОНДО” ХХК-тай байгуулсан 2022/92 дугаартай “Интернет үйлчилгээний гэрээ”-ний хугацааг сунгаж, нэмэлт гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.
3. “ОНДО” ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтаар баталсан нөхцөлийн дагуу “Интернет үйлчилгээний нэмэлт гэрээ”-г байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, холбогдох бусад арга хэмжээ авах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

